



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 8147

Улаанбаатар хот

Г
Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.13 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх” журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2002 оны 264, 2009 оны 99 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР



Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 04 сарын 29 өдрийн
дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЯВУУЛЫН ХЭЛБЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх (цаашид явуулын тусlamж, үйлчилгээ гэх) зорилго нь бүх нийтийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд хамруулах зорилтыг хангах, алслагдсан болон газарзүйн бэрхшээлтэй орон нутагт очиж амбулаторийн болон нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэхэд оршино.
2. Явуулын тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.
3. Явуулын тусlamж, үйлчилгээ үзүүлэхдээ Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.
4. Явуулын тусlamж, үйлчилгээг жилд 2 удаа тогтмол зохион байгуулна. Цаг үеийн шаардлагаар нэмэлтээр зохион байгуулах ажлыг тухай бүр холбогдох хууль тогтоомжинд нийцүүлнэ.
5. Хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол тухайн тусlamж, үйлчилгээ, эм хангамжийн үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

Хоёр. Явуулын хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хамрах хүрээ

Явуулын хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг дараах иргэдэд үзүүлнэ.

1. Алслагдсан болон газарзүйн бэрхшээлтэй сум, баг, тосгоны хүн ам
2. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг болон отор нүүдэл хийж байгаа малчид
3. Орон нутагт тариалан эрхэлж буй тариаланчид
4. Бичил уурхай эрхлэгчид

Гурав. Явуулын хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний багц

Явуулын хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ нь дараах багц тусlamж, үйлчилгээнээс бүрдэнэ.

1. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ
 - 1.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг
 - 1.2. Нөхөн болон нэмэлт дархлаажуулалт
 - 1.3. Эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт сурталчилгаа
 - 1.4. Нийгмийн хalamж дэмжлэг шаардлагатай өрх, иргэнийг илрүүлж, холбогдох байгууллагад мэдэгдэх зуучлалын үйлчилгээ
2. Амбулаторийн тусlamж, үйлчилгээ
 - 2.1. Эх, хүүхдийн эрүүл мэнд, жирэмсний хяналт, эх барих, нярайд үзүүлэх тусlamж үйлчилгээ.
 - 2.2. Халдварт өвчний тусlamж үйлчилгээ
 - 2.3. Өвчний идэвхтэй хяналт
 - 2.4. Лавлагаа тусlamж, үйлчилгээ
 - 2.5. Эмнэлгийн зориулалтаар тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй бол мэс ажилбар, шүдний эмчилгээ, холбогдох бусад шаардлагатай оношилгоо, шинжилгээ, эмчилгээ
3. Эм зүйн тусlamж, үйлчилгээ
 - 3.1. Зайлшгүй шаардлагатай, яаралтай тусlamжийн эм
 - 3.2. Үзлэг, шинжилгээ, эмчилгээнд шууд хэрэглэгдэх эм хэрэгсэл, оношлуур

Дөрөв. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэхэд Эрүүл мэндийн газрын хүлээх үүрэг

1. Алслагдсан болон газарзүйн бэрхшээлтэй сум, баг, тосгоны хүн амд “Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх” ажлыг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.
2. Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ, өвчлөл, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал, хүний нөөцөд тохируулан үйл ажиллагааг төлөвлөнө.
3. Явуулын тусlamж, үйлчилгээний төлөвлөгөөг гаргах, зохион байгуулахдаа тухайн үйлчилгээнд хамрагдах сум, тосгоны эрүүл мэндийн төв, багийн эмч нараас саналыг нь авсан байна.
4. Явуулын хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөр гүйцэтгүүлнэ.
5. Явуулын тусlamж, үйлчилгээнд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг татан оролцуулж болно. Энэ асуудлыг тухайн мэргэжилтний харьяалах тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагатай нь зөвшилцэж, шийдвэрлэнэ.

6. Явуулын тусламж, үйлчилгээг улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгал, төрийн, төрийн бус, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагууд, иргэдийн хандив тусламж, дэмжлэгт тулгуурлан холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн санхүүжүүлж болно.

7. Явуулын тусламж, үйлчилгээ үзүүлсэн ажлын тайланг аймгийн нэгдсэн тайланд тусгана.

8. Эрүүл мэндийн газрын тухайн жилийн үйл ажиллагааны тайланд явуулын тусламж, үйлчилгээнд хамруулсан хүний тоог энэ журмын 2 дахь хэсэгт заасан ангиллаар гаргаж, илрүүлсэн өвчлөл, эмчлэн эрүүлжүүлсэн хувь, хяналтад авсан хувь, нийгмийн халамж дэмжлэг, шаардлагатай өрх иргэнийг холбогдох байгууллагад зуучилсан байдал, зарцуулсан хөрөнгө, түүний эх үүсвэрийн талаар тусгана.

Тав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх багийн үүрэг

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэхдээ багийн гишүүдийн болон тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, стандартыг чанд сахина.

2. Халдвартын сэргийлэлт, хяналтын чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагаас баталсан заавар, аргачлалыг мөрдлөг болгон ажиллана.

3. Эм, хэрэгслийн зарцуулалтад холбогдох дүрэм журам, стандартад заагдсан шаардлагыг хангана.

4. Оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж болон холбогдох бусад техник хэрэгсэл нь эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан, эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн онцлогт нийцсэн байна.

5. Явуулын тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ эрүүл мэндийн байгууллагын төрлөөр заасан зайлшгүй шаардлагатай эмийн нөөцтэй байна.

Зургаа. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүлээн авах орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1. Эрүүл мэндийн явуулын тусламж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх төлөвлөгөөнд санал өгөх, зохион байгуулахад оролцох

2. Явуулын тусламж, үйлчилгээнд хамрах хүн амын судалгааг гаргаж, үзлэгийн өдөр, цаг, байршлыг товлох, очих газрын байрлалын зураглал гаргаж хөтөч ажиллуулах

3. Явуулын тусламж, үйлчилгээний багийн гишүүдийг байрлуулах, хоол хүнсээр үйлчлэх ажилд дэмжлэг үзүүлэх,

4. Орон нутгийн засаг захиргааны байгууллагыг мэдээллээр хангаж, хамтран ажиллах

Долоо. Шаардлагатай тоног төхөөрөмж

1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх баг нь дараах эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан байна.

- 1.1. Даралтын аппарат, чагнуур
- 1.2. Стетоскоп
- 1.3. Зөөврийн эхо аппарат
- 1.4. Зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат
- 1.5. Глюкозметр
- 1.6. Хурдавчилсан оношлуурууд
- 1.7. Нүдний даралт хэмжигч
- 1.8. Чих хамар, хоолойн тусlamжийн багаж хэрэгсэл
- 1.9. Жижиг мэс ажилбарын багаж, хэрэгсэл
- 1.10. Ороох боох материал
- 1.11. Мэдээлэл сургалт сурталчилгааны хэвлэмэл материалууд
- 1.12. Зөөврийн рентген аппарат, шүдний борын аппарат, тархины цахилгаан бичлэгийн аппарат /боломжтой бол/

2. Эмнэлгийн бус тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагаанд шаардагдах дараах багаж хэрэгслийг бэлэн байлгана.

- 2.1. Машины засварын багаж хэрэгсэл
- 2.2. Зөөврийн цахилгаан үүсгүүр
- 2.3. Хүрз, жоотуу
- 2.4. Гар чийдэн, Лаа шүдэнз
- 2.5. Хийн плитка
- 2.6. GPS утас
- 2.7. Саваа мод, нөөц түлээ
- 2.8. Олс татлага
- 2.9. Үндны цэвэр ус, ойр зуурын илчлэг ихтэй авсаархан хүнс
- 2.10. Усны гутал, борооны цув, дулаан хувцас
- 2.11. Майхан, эвхдэг ширээ, сандал

Найм. Хориглох зүйл

1. Эрүүл мэндийн газартай харилцан зөвшилцөөгүй эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэхийг хориглоно.
2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагад харьяалагддаггүй эмнэлгийн мэргэжилтэн сайн дураар баг үүсгэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэхийг хориглоно.
3. Энэ журмын 3.1-д зааснаас бусад тусlamж, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.